

## ӨМНӨХ ҮГ

Монгол Улсын Их Сургуулийн Хүн амын сургалт, судалгааны төв, Монголын хүн ам, хөгжил нийгэмлэгтэй хамтран “Монголын хүн амын сэтгүүл”-ийн 32 дахь дугаараа бэлтгэн, эрхэм уншигч Та бүхэнд толилуулж байна.

“Монголын Хүн Амын Сэтгүүл” нь Монголын хүн ам зүйн талбарт тулгамдаж байгаа болон хүн ам, нийгэм, жендэр, хүний хөгжлийн бусад асуудлаар эрдэмтэд, судлаачдын хийсэн судалгаа, эрдэм шинжилгээний бүтээл; мэргэжлийн дүн шинжилгээний нарийн техник, арга зүйн сургалт; асуудал хөндсөн шүүмж үзэл бодлыг хөгжлийн бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчид, мэргэжилтэн, олон улсын донор байгууллагууд, судлаачид, оюутнууд болон сонирхсон бусад олон нийтэд түгээн дэлгэрүүлэх зорилгоор бэлтгэгддэг Монгол Улсын Сургуулийн эрдмийн бичиг юм.

Монголын хүн амын сэтгүүлийг 1996 оноос хойш тасралтгүй бэлтгэн хэвлүүлж байгаа бөгөөд эрхэм уншигч та бүхэн онлайн хэлбэрээр сэтгүүлийн өмнөх бүх дугаарыг МУИС-ийн төв номын сангаас авч унших боломжтой.

Сэтгүүлийн энэ удаагийн дугаарт Монгол улсын хүн амын гадаад шилжих хөдөлгөөний мэдээлэл, түүний чанарын асуудлууд, дотоод шилжих хөдөлгөөний газарзүйн байршлын асуудлууд, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтэд асран халамжлах ажлын үзүүлж буй нөлөө, Монгол улсын хүн ам, өрхийн амьжиргаанд гарч буй өөрчлөлт зэрэг олон сонирхолтой асуудал хөндсөн эрдэм шинжилгээний өгүүлүүдийг судалгааны Монгол хэсгээр та бүхэнд танилцуулж байна.

Сургалт хэсэгтээ, Нийгмийн халамжаас хараат байдлыг үнэлэх, нийгмийн хамгааллын системд гарах үр дүнг сайжруулах арга аргачлал, Ковид-19 цар тахлын цочиролд хариу үзүүлэх нийгмийн хамгааллын бодлогын сургамж, үр дагаврын талаар нийгэм, хүн ам зүйн судлаачдын олон улсын хамтарсан төслийн хүрээнд бэлтгэсэн бодлогын 3 тойм хураангуйг толилуулж байна.

Судалгааны Англи хэсэгтээ, Ковид 19 цар тахлын Монголын эмзэг бүлгийн охид, эмэгтэйчүүдэд үзүүлсэн нөлөөг үнэлсэн чанарын судалгааны үр дүн, мөн цар тахлын үед боловсролын дижитал сургалтын арга зүйг багш нар хэрхэн ашиглаж, ур чадвараа дээшлүүлж байгаа, тэдгээрт тулгарч буй асуудлыг хөндсөн судалгааны үр дүнг танилцуулж байна.

Сэтгүүлийн энэ удаагийн дугаарт толилуулж буй судалгаа, эрдэм шинжилгээний ажил, эрдэмтэн, судлаачдын үзэл бодлын талаар эрхэм уншигч Та шүүмж, мэтгэлцээн, хэлэлцүүлэг өрнүүлэн, санал бодлоо хуваалцаж, манай дараагийн дугаарт өөрийн материалаа ирүүлнэ гэдэгт бид итгэлтэй байна. Сэтгүүлийг цахим хэлбэрээр МУИС-ийн вебсайтаас унших боломжтой.

Энэ ялдамд хүн ам зүй, хүн ам, хөгжлийн асуудлаар судалгаа, шинжилгээний ажилд оюун санаагаа зориулан манай сэтгүүлд өөрийн бүтээлээ ирүүлсэн нийт эрдэмтэн, судлаачид болон уг сэтгүүлийн энэ дугаарыг бэлтгэн хэвлэхэд санхүүгийн дэмжлэг, туслалцаа үзүүлсэн Монгол улсын их сургуульд сэтгүүлийн редакцийн хамт олон гүн талархлаа илэрхийлж байна.

Эрхэм уншигч таны оюуны мэлмий тань тэлэх болтугай.

**РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ**